



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 05.

Цагаан дэнж

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал  
түүний Тэргүүлэгчдийн 2019 оны ажлын  
төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн Нэгж түүний Удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний Тэргүүлэгчдийн 2019 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.


2. Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч төлөвлөгөөтэй уялдуулан улирал бүр нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тооцон ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Н.Дэмбэрэлд даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХБААТАР

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын  
18-ны өдрийн 05 тоот тогтоолоор батлав.



## СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2019 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Эрхэм зорилго:** Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж, төлөвшүүлэн, сум орон нутгийнхаа нийгэм эдийн засгийг хөгжүүлэн, иргэдийнхээ төлөөлөх эрхийг хангана.

№	Төлөвлөгөөний үндсэн чиглэл	Хийх ажлын үндсэн чиглэл	Хариуцах эзэн	Хугацаа	Гарах үр дүн /Шалгуур үзүүлэлт/
1	2	3	4	5	6
1	ИТХ-ын ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцэх асуудлууд	1. Сумын ИТХ, Тэргүүлэгчдээс 2019 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан	Б.Энхбаатар	12/15	Ажлын биелэлт, үр дүнг тооцсоноор
		2. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны хэрэгжилт	Ц.Төмөрбаатар Д.Цэвэгдорж	12/15	Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцсоноор
		3. Сумын нийгэм эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2020 оны үндсэн чиглэл батлах	Ц.Төмөрбаатар Д.Цэвэгдорж	12/15	Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг тооцон, 2018 оны үндсэн чиглэл батлагдсанаар
		4. Сумын 2019 оны төсвийн гүйцэтгэл, 2020 оны төсвийг хэлэлцэх	Ц.Мөнхбаатар	12/15	Төсвийн зарцуулалт, үр дүнг дүгнэн, 2018 оны төсвийг баталснаар
		5. Газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2020 оны төлөвлөгөө батлах	Газрын даамал	12/15	Төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тооцон, 2018 оны төлөвлөгөөг баталснаар
		6. Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмыг шинэчлэх, Төлбөрийн хувь шинэчлэн тогтох тухай, Хог хаягдлын журмыг батлах	МЭҮТ, Газрын даамал, Байгаль орчны алба	1-р улиралд	Журмуудыг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, Хууль зүйн яаманд хүргүүлж хянуулан эрх зүйн актад бүртгүүлсэнээр
		7. Бусад асуудал		Жилдээ	
		1. Сумын сайн малчид, Сумын алдарт уяач, Сумын хөдөлмөрийн аваргуудыг шалгаруулах	Б. Хандмаа Б.Мөнхтуул	01/20	Болзлыг дүгнэн шалгаруулсанаар

1	2	3	4	5	6
2	Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд	2. Иргэдийг төрийн дээд одон медальд тодорхойлох	Н.Дэмбэрэл Р.Болормаа	Жилдээ	шагналд тодорхойлосноор иргэдийг шагналд тодорхойлосноор
		3. “Алдарт эх” 1,2-р одонд эхчүүдийг тодорхойлох	Б.Мөнхтуул Н.Дэмбэрэл	2/25	Эхчүүдийн материалыг бүрдүүлж сумын ИТХ-аар хэлэлцүүлэн дээд шатны байгууллагад уламжлан шагнуулсанаар
		4. Байгууллагуудын тайлан, дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй танилцах /2019 он/	Ерөнхий менежерүүд	06/13	Ажлын тайланг хэлэлцэн үр дүнг тооцсоноор
		5. Өвөлжилтийн бэлтгэл ажлын мэдээлэл	Д.Цэвэгдорж	10/03	Өвөлжилтийн бэлтгэл ажил хангагдсанаар
		6. Өвөл цагийн соёл мэдээллийн ажлын 2018-2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2019-2020 оны төлөвлөгөө батлах	Б.Мөнхтуул Л.Ганчимэг	09/26	Төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг тооцсоноор
		7. Төсөвт байгууллагуудад эд хөрөнгийн тооллого хийлгэн актлах устгах хөрөнгийн саналыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт уламжлан шийдвэрлэж ажиллана.	Б.Энхбаатар Н.Дэмбэрэл	6 сард	Төсөвт байгууллагуудын актлах, устгах хөрөнгийн саналыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт уламжлан шийдвэрлүүлсэнээр
		8. Хүн амын хөгжлийн салбар хороог байгуулах	Б.Мөнхтуул	1-р улиралд	Салбар хороог байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулсан байх
		9. Аймгийн “Торгон сүрэг” хөтөлбөр, “Илгээлтийн эзэн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган батлах	Б.Хандмаа Ц.Бямбасүрэн	1-р улиралд	Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг тооцсоноор
		10. Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх бусад асуудлыг тухай бүр хэлэлцэнэ.		Тухай бүрт	
		3	НӨУБ-ын үйл ажиллагааг	1. Байгууллага сурталчилах 14 хоногийн аяны хүрээнд арга хэмжээ болон уралдаан тэмцээн зохион байгуулах	ИТХ-ын Төлөөлөгчид, Тэргүүлэгчид Ажлын алба

1	2	3	4	5	6
	нээлттэй, олон нийтийн оролцоог хангаж ажиллах талаар хийх ажлууд	2. БИНХ-ыг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулж, баг бүрт өдөрлөг, урлаг соёлын арга хэмжээ зохион байгуулах	Тэргүүлэгчид Ажлын алба	5,8,10 сард	Олон нийтийн оролцоог нэмэгдүүлсэнээр
		3. Сумын ИТХ-ын дарга багийн ИНХ-ын дарга нартай хамтран ажиллах гэрээний биелэлтийг улирал бүр тооцон ажиллах	Б.Энхбаатар Н.Дэмбэрэл	Улирал бүр	Хамтран ажиллах гэрээг улирал бүр дүгнэсэнээр
		4. Хурлаас гарах шийдвэрт иргэдийн саналыг тусгах	Тэргүүлэгчид Ажлын алба	Жилдээ	НӨУБ, иргэдийн эргэх холбоог хамтын ажиллагааг нэмэгдүүлсэнээр
4	Хяналт шалгалтын чиглэлээр	1. “Үдийн цай” хөтөлбөрт хяналт шалгалт хийх	Нийгмийн бодлогын хороо Тэргүүлэгчид	1-р улиралд	Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг тооцсоноор
		2. Сургуулийн дотуур байрны үйл ажиллагаа, хүүхдүүдийн амьдрал ахуйтай танилцах	Нийгмийн бодлогын хороо, Тэргүүлэгчид	1-р улиралд	Сургуулийн дотуур байрны үйл ажиллагаатай танилцаж үнэлэлт дүгнэлт өгч ажиллах
		3. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд хяналт тавих	Санхүүгийн хороо Хяналтын зөвлөл	Жилдээ	Хөрөнгийн зарцуулалт, ажлын чанар, үр дүнг тооцсоноор
		4. Сум хөгжүүлэх сангаас зээл авсан төслийн хэрэгжилтэнд хяналт тавих	Санхүүгийн хороо Тэргүүлэгчид	Жилдээ	Төслийн хэрэгжилт, үр дүнг тооцсоноор
5	Дотоод ажил, сургалт сурталчилгаа	1. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгчдийн нэг өдрийг баг бүрт зохион байгуулах	ИТХ-ын Төлөөлөгчид	2, 3-р улиралд	Төлөөлөгчдийн нэг өдрийг зохион байгуулсанаар
		2. Аймаг, сумын ИТХ, Тэргүүлэгчдээс гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэх	Н.Дэмбэрэл	6/15 12/25	Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тооцсоноор
		3. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг ханган, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтыг хүлээн авах	Ажлын алба	Жилдээ	Архивын нэгжийг бүрдүүлсэнээр
		4. Архивын баримтыг цахим хэлбэрээр Төрийн архивын тасагт хүлээлгэн өгөх	Н.Дэмбэрэл Б.Өсөхбөяр	Жилдээ	Цахим сан бүрдүүлсэнээр
		5. Байгууллагын ажилчдын хувийн хэргийг шинэчлэн баяжуулах	Н.Дэмбэрэл	1-р улиралд	Хувийн хэрэгт баяжилт хийсэнээр
		6. Тогтоол шийдвэр мэдээллийг сурталчилсан самбар байрлуулах	Б.Энхбаатар Н.Дэмбэрэл	1-р улиралд	Мэдээллийг нийтэд мэдээлсэнээр

1	2	3	4	5	6
		7. БИНХ-ын дарга нарт хууль эрх зүйн зөвлөгөө, сургалт зохион байгуулах	Ажлын алба	2-р улиралд	Арга зүйн зөвлөмж хүргүүлсэнээр
		8. Байгууллагаас гаргаж байгаа судалгаа, танилцуулгыг хөтлөх	Ажлын алба	Жилдээ	Байгууллагын танилцуулгыг тогтмол хөтлөх , холбогдох судалгааг гаргаж байх
		9. Сумын ИТХ-ын сайтыг тогтмол хөгжүүлж байнга мэдээлэл оруулж байх	Н.Дэмбэрэл	Жилдээ	Сумын ИТХ-ын сайтыг хөгжүүлж мэдээллийн баазыг баяжуулсанаар
		10. ИТХ-ын төлөөлөгчид болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оролцсон бүртгэл хөтлөх	Н.Дэмбэрэл	Жилдээ	Ирцийн бүртгэл хөтөлсөнөөр

.....ооо.....